



**“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 25 өдөр

№ 01

Чойбалсан хот

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Дорнод худалдаа” ХК-ийн 2018 оны
04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын
01 дугаар тогтоолыг үндэслэн тус тус ТОГТООХ НЬ:

1. Дорнод худалдаа ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч
баталсугай

ХУРЛЫН ДАРГА..... / Д.ШИНЭБАЯР /





**“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 25 өдөр

№ 02

Чойбалсан хот

Компанийн ногдол ашиг тараахгүй тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Дорнод худалдаа” ХК-ийн 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг үндэслэн тус тус **ТОГТООХ НЬ:**

1. Дорнод худалдаа ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан ногдол ашиг хувиарлахгүй гэсэн шийдвэрийг зөвшөөрсугай.

ХУРЛЫН ДАРГА / Д.ШИНЭБАЯР /





“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 25 өдөр

№ 03

Чойбалсан хот

Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Дорнод худалдаа” ХК-ийн 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг нь үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дорнод худалдаа” ХК -ийн 2018 оны Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан бизнес төлөвлөгөөг эцэслэн баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан бизнес төлөвлөгөөг компанийн эдийн засаг, санхүүтэй уялдуулан шат дараалалтай хийж гүйцэтгэхийг компанийн удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА..... / Д.ШИНЭБАЯР /





**“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 25 өдөр

№ 04

Чойбалсан хот

Компанийн урт хугацаат өр төлбөр барагдуулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Дорнод худалдаа” ХК-ийн 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн арилжааны банкнаас авсан урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийг үл хөдлөх хөрөнгө худалдаж төлж барагдуулахыг зөвшөөрсугай.
2. Үл хөдлөх хөрөнгө худалдаж өр төлбөр барагдуулах ажлыг компанийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА..... / Д.ШИНЭБАЯР /





**“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 дүгээр сарын 25 өдөр

№ 05

Чойбалсан хот

Компанийн үл хөдлөх хөрөнгө худалдах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1, 62.1.15 дэх заалт, “Дорнод худалдаа” ХК-ийн 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 05 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Y-0611024157 тоот гэрчилгээний дугаартай СМУ-д байрлалтай АФТА ХХК-ийн түрээслэж буй 200мкв талбай бүхий улаан дэлгүүрийн барилгыг худалдах эрхийг компанийн гүйцэтгэх удирдлагад, төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Үл хөдлөх хөрөнгийн худалдах үнийг компанийн тухай хуулийн 87.2 дэх зүйлд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА..... / Д.ШИНЭБАЯР /

